

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

**2025-2028 ОНЫ ДУНД  
ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Боловсруулсан:**

**А.Анхбаяр**

**Б.Баттөгс**

**Л.Цэрэнбүтэд**

## УДИРТГАЛ

бөгөөд тодорхой хэтийн зорилго, хүрэх үр дүн бүхий стратеги төлөвлөгөөг боловсруулсан нь бидний цаашдын ажилд тулгуур үндэслэл болох юм.

Төсвийн тухай хуулийн дагуу санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхдээ тухайн байгууллагын бодлого, горим, үйл ажиллагааг системийн бодит байдалд тулгуурлан үнэлж, зохих зөвлөмж, шийдвэрүүдийг гаргах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, эрсдэлийн менежментийг нэвтрүүлж, эрсдэлийн судалгаа баазыг өргөжүүлэх замаар эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Энэхүү зорилтыг ханган биелүүлэхийн тулд давуу талыг бататгаж, боломжуудыг ашиглан, сул талыг бууруулах замаар тулгарч болзошгүй эрсдэлийг даван туулахад чиглэсэн үйл ажиллагааны хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлсон болно.

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН МЭДЭГДЭЛ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь ирэх 4 жилд 2025-2028 онд төрийн албан хаагчдын мэргэжил, ур чадварыг байнга дээшлүүлж тэдний ажиллах ая тухтай таатай орчинг бүрдүүлж ажиллана. Үүнд:

1. Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторыг сургалтанд байнга хамруулж, тэдний ажиллах ур чадвар, мэдлэг мэргэжлийг дээшлүүлнэ.
2. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
3. Батлагдсан төсвийн хүрээнд болон хамт олны нөөц бололцоогоор ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.
4. Төсөвлөсөн хөрөнгийг үр ашигтай зарцуулан түүнд тавих хяналтыг сайжруулж холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, үр ашигтай зарцуулна.
5. Хүн бүр эх хэл, соёлоо дээдэлж зөв бичиж хэрэглэж хэвших, байгууллага хамт олон “Бүх нийтээрээ хос бичигтэн” болоход уриалсан нөлөөлийн ажлуудыг зохион байгуулах, сургалтад хамруулж, мэдлэг боловсролыг дээшлүүлнэ.

Төсвийн шууд захирагч:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга

Б.Баттулга

2025 оны 01 сарын 17-ны өдөр

## **НЭГ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2025-2028**

### **БУЛГАН АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ТАНИЛЦУУЛГА**

Санхүүгийн хяналт, аудитын алба нь Монгол Улсын Засгийн газрын 327 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын газарт байсан санхүүгийн хяналт шалгалтын чиг үүргийг шилжүүлснээр аймгийн Засаг даргын 2015 оны Б/12 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нэртэйгээр байгуулагдан ажиллаж байна.

Тус алба 2015 онд аймгийн Засаг даргын захирамжаар баталсан бүтэц, орон тооны зохион байгуулалтаар 9 орон тоотой байхаар сангийн яамнаас баталсан боловч одоогоор 8 орон тоотойгоор албаны дарга 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч 2 дотоод аудитор 3, жолооч 1, нягтлан бодогчийн орон тоо дутуу ажиллаж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудад Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон санхүү, бүртгэлийн холбогдолтой хууль, дүрэм, журам, стандарт, норм нормативын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор Санхүүгийн хяналт, аудитын алба нэршлийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болгон өөрчилсөн.

## **АЛСЫН ХАРАА:**

Хууль ёсыг дээдлэх, санхүүгийн сахилга батыг сайжруулах, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэхийн төлөө

## **ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдүүдийн хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд хийх санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудит хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангахад Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны эрхэм зорилго оршино.

## **ЗОРИЛГО:**

Төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах, болзошгүй эрсдлийг бууруулах замаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд байгууллагад туслах

## **ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ҮНЭТ ЗҮЙЛ**

Бид: Санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудитыг хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ.

Бид: Хараат бус, бодитой баталгаажуулах, зөвлөх үйл ажиллагааг ил тод, үр нөлөө, үр ашигтай байхаар гүйцэтгэнэ.

Бид: Шалгуулагч этгээдэд адил тэгш хандаж, хууль ёсны эрхийг хамгаалан хүндэтгэн харилцана.

## **ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО**

### **Хөгжлийн зорилго 1**

Удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, харилцаа хамтын ажиллагааны удирдлагыг сайжруулна.

### **Хөгжлийн зорилго 2**

Мэдлэгт суурилсан, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлнэ.

### **Хөгжлийн зорилго 3**

Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

### **Хөгжлийн зорилго 4**

Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, төсвийн ил тод байдлыг хангана.

## **Удирдлага, зохион байгуулалтын хөгжлийн зорилго**

Удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, харилцаа хамтын ажиллагааны удирдлагыг сайжруулна.

### **Зорилтууд:**

1. Байгууллагын өөрийн удирдлагыг бэхжүүлж, менежментийн чадамжийг дээшлүүлэх
2. Байгууллагын соёл, дэг журмыг сахин биелүүлэх
3. Байгууллагын дотоод хяналтыг төлөвшүүлж, үр дүнг дээшлүүлэх
4. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг харилцан уялдаатай, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд харилцагч, хамтран ажиллагч төрийн байгууллагуудын ажиллагаа, үр ашигтай түншлэлийг өргөжүүлж, тэдний идэвхи оролцоог бий болгох

## **Хүний нөөцийн хөгжлийн зорилго**

Мэдлэгт суурилсан чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлнэ.

### **Зорилтууд:**

1. Ажилтнуудын сургалтын хэрэгцээг нарийвчлан тодорхойлж, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлэх
2. Хүний нөөцийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулан албан тушаалын тодорхойлолтод тусгах
3. Төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэв ахиулах, албан тушаалд дэвшүүлэх бодлогын зөв, оновчтой, ил тод тогтолцоог бүрдүүлж, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх

## **Нийгмийн хангамжийн хөгжлийн зорилго**

Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

### **Зорилтууд:**

1. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмолжуулах
2. Ажилтнуудын нийгмийн гол асуудал болох орон сууцны нөхцөлийг сайжруулах
3. Хамт олны нийгмийн бусад нийтлэг асуудлыг шийдвэрлэх

## **Санхүүгийн хөгжлийн зорилго**

Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангана.

### **Зорилтууд:**

1. Төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж өр авлагагүй ажиллах
2. Төсвийн гүйцэтгэл, мэдээ тайлан ил тод байх
3. Шилэн дансанд мэдээллийг тухай бүр байршуулж байх

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Хэрэгжүүлэх стратеги зорилтууд	Үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд	Шалгуур үзүүлэлтүүд
<i>Нээ.Удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож харилцаа хамтын ажиллагааны удирдлагыг сайжруулна.</i>		
1.1 Байгууллагын өөрийн удирдлагыг бэхжүүлж, менежментийн чадамжийг дээшлүүлэх	Байгууллагын менежментийг сайжруулах	Тухайн оны өсөлт, бууралтын хувь
1.2 Байгууллагын соёл, дэг журмыг сахин биелүүлэх	Захирах, захирагдах ёсны зарчмыг баримтлах  Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, ёс зүйтэй хяналтыг төлөвшүүлэн, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах  Төрийн үйлчилгээг цаг алдалгүй, олон нийтэд чанартай, хүртээмжтэй соёлтой хүргэж, тэдний итгэл үнэмшлийг хүлээх	
1.3 Байгууллагын дотоод хяналтыг төлөвшүүлж, үр дүнг дээшлүүлэх	Байгууллагын дотоод хяналтын журмыг боловсронгуй болгож, төлөвлөгөөт хяналтыг тогтмолжуулж, үр дүнг хамт олны хурлаар хэлэлцүүлэх, тайлагнах  Дотоод хяналтын бүртгэлийг нэгж бүрт хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх	Дотоод хяналтыг улирал бүр хийж, үр дүнг тооцох  Мэдээллийн сантай болох
1.4.Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг харилцан уялдаатай, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд харилцагч, хамтран ажиллагч төрийн байгууллагуудын ажиллагаа, үр ашигтай түншлэлийг өргөжүүлж, тэдний идэвхи оролцоог бий болгох	Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шалгалтын дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх, шаардлагатай тохиолдолд төрийн бусад байгууллагуудтай хамтарч ажиллах	



*Хоёр.Мэдлэгт суурилсан суралцагч байгууллагыг хөгжүүлж, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлнэ.*

<p>2.1 Ажилтнуудын сургалтын хэрэгцээг нарийвчлан тодорхойлж, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлэх</p>	<p>Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, эрх сунгах, тасралтгүй боловсрол олгох сургалтуудад хамруулах</p> <p>Дотоод аудитын үндсэн мэдлэг олгох сургалтанд аудиторудыг бүрэн хамруулах</p> <p>Улсын салбарын мэргэшсэн дотоод аудиторын давтан сургалтанд аудиторудыг бүрэн хамруулах</p>	<p>Мэргэшсэн нягтлан бодогчийн тоо</p> <p>Сургалтанд хамрагдсан ажилтны тоо</p> <p>Сургалтанд хамрагдсан ажилтны тоо</p>
<p>2.2 Хүний нөөцийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулан албан тушаалын тодорхойлолтод тусгах</p>	<p>Ажлын ачааллын бодит байдлын талаар судалгаа хийх</p> <p>Ажлын байрны шинжилгээнд үндэслэн, ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэх</p>	<p>Шинжилгээ хийгдсэн ажлын байрны тоо</p> <p>Шинэчлэн боловсруулсан ажлын байрны тодорхойлолт</p>
<p>2.3 Төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэв ахиулах, албан тушаалд дэвшүүлэх бодлогын зөв, оновчтой, ил тод тогтолцоог бүрдүүлж, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх</p>	<p>Хөдөлмөрийн бүтээмжийг бодитой үнэлдэг тогтолцоог бий болгож, байгууллагын дотоод дүрэм, журамд тусгах</p>	<p>Дүрэм, журамд орсон нааштай өөрчлөлтийн тоо</p> <p>Албан тушаал болон зэрэг дэв ахисан ажилтны тоо</p>

*Гурав. Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.*

<p>3.1. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмолжуулах</p>	<p>Ажилтнуудыг эрүүл мэндийн бүрдмэл үзлэгт жил бүр төлөвлөгөөний дагуу хамруулах</p>	<p>Үзлэгт хамрагдсан ажилтнуудын тоо</p>
<p>3.2 Ажилтнуудын нийгмийн гол асуудал болох орон сууцны нөхцөлийг сайжруулах</p>	<p>Орон сууцны хэрэгцээний талаар бодитой судалгаа гаргах</p> <p>Орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь бодит тусалцаа үзүүлэх</p>	<p>Энэ чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалт мөнгөн дүн</p>
<p>3.3 Хамт олны нийгмийн бусад нийтлэг асуудлыг шийдвэрлэх</p>	<p>Тусламж: Орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь зориулан нэг удаагийн санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх</p>	

	<p>Шинээр гэр бүл болоход нь санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх</p> <p>Хүүхэд төрүүлэх, хүүхэд үрчлэн авахад нь санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх</p> <p>Тэтгэмж: Хүнд өвчтэй гэр бүлийн гишүүд (эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд)-ээ ажлаасаа чөлөөлөгдөн асарвал тэтгэмж олгох</p> <p>Байгалийн гамшиг, гэнэтийн осолд орж, орон байр, эд хөрөнгөний ноцтой хохирол учирсан тохиолдолд тэтгэмж олгох</p> <p>Удаан хугацаагаар өвчилсөн тохиолдолд тэтгэмж олгох</p>	<p>Нэг удаагийн буцалтгүй тусламжид хамрагдагсдын хувь</p> <p>Санхүүгийн тусламж, тэтгэмж хүртэгсдийн тоо, мөнгөн дүн</p>
<i>Дөрөв. Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангасан байна</i>		
1. Төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж өр авлагагүй ажиллах	<p>Урсгал зардлыг бодитой зарцуулж, төсвийн хэтрэлт гаргахгүй байх</p> <p>Анхан шатны бүртгэлийг бүрэн гүйцэд хөтөлж хэвших</p>	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр
2. Төсвийн гүйцэтгэл, мэдээ тайлан ил тод байх	<p>Санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг жил бүр тайлагнаж, хэвшүүлэх</p> <p>Санхүүгийн сахилгыг мөрдөж ажиллах</p>	Санхүү, төрийн сангийн хэлтэст тайлагнасан, тушаасан байдлаар
3. Шилэн дансанд мэдээллийг тухай бүр байршуулж байх	Санхүүгийн холбогдолтой мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр Шилэн дансанд байршуулж мэдээлэх	<a href="http://www.Shilendans.gov.mn">www.Shilendans.gov.mn</a> сайтаар шалгах
4. Шил ажиллагааны тайлан мэдээг тухай бүр байршуулж,	НИТБТХуулийн дагуу шилэн ажиллагааны тайланг хуулийн хугацаанд тухай бүр Шил ажиллагааны нэгдсэн системд мэдээлж байх	<a href="http://Shilen.gov.mn">Shilen.gov.mn</a> сайтад мэдээллийг ил тод байршуулах

### ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

- Гүйцэтгэлийн үр дүн, чанар сайжирна
- Хүний нөөцийн удирдлага бэхжинэ.
- Орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтэрнэ.
- Ажилтнуудын нийгмийн асуудал шийдэгдэнэ.

Давуу тал	Сул тал
<p><i>1. Бүтэц, зохион байгуулалт</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хараат бус тогтолцоо бүрдсэн</li> <li>- Нэгдсэн төлөвлөгөөт зохион байгуулалтаар хяналтыг жил бүр хийдэг.</li> </ul>	<p><i>1. Бүтэц, зохион байгуулалт</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй.</li> <li>- Байгууллагын үйл ажиллагааны зохицуулалт, хүний нөөц хангалтгүй</li> </ul>

<p><b>2.Нөөц</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сургалт сурталчилгаа хийх боломжтой</li> <li>- Мэргэжлийн, ажлын туршлагатай боловсон хүчин бүрдсэн.</li> </ul> <p><b>3.Гарц</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомийн хэрэгжилтийг сайжруулж, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх</li> <li>- Байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлж, эрсдлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгөх</li> </ul> <p><b>4. Байгууллагын соёл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн төсвийн бүрдүүлэлт, үр ашигтай зарцуулж байгаа эсэх, хуулийн хэрэгжилтийг хангуулахын төлөө ажилладаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улсын байцаагчдын аюулгүй байдлын баталгаа хангагдаагүй.</li> <li>- Идэвхижүүлэлтийн үйл ажиллагаа сул</li> <li>- Дотоод хяналт төлөвшөөгүй.</li> <li>- Ажилтнуудын ёс зүйн хариуцлагын тогтолцоо, хариуцлага тооцох механизм сул</li> </ul> <p><b>2.Нөөц</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүний нөөц дутмаг</li> <li>- Мэргэшүүлэх сургалтын тасралтгүй тогтолцоо байхгүй</li> <li>- Хүний нөөцийн чадавхийг шинэ хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх, хөгжүүлэх үйл явц удаашралтай</li> <li>- Төсвийн санхүүжилт үйл ажиллагаанд хүрэлцдэггүй.</li> </ul> <p><b>3.Гарц</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Шийдвэрийн биелэлт хангалтгүй.</li> <li>- Хяналтын ажилд чанарын үнэлгээ хийгддэггүй.</li> </ul> <p><b>4.Байгууллагын соёл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Байцаагчдын үйл ажиллагаанд хяналт шалгалт зонхилж байгаагаас олон нийтийн дунд байгууллагын үйл ажиллагааг үнэлэх үнэлэмж сул.</li> <li>- Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хөндлөнгийн нөлөөлөл ихтэй</li> </ul>
---	---

<p style="text-align: center;"><b>Улс төр</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>Шууд нөлөөлөл</b></li> </ul> <p>Улс төрийн тогтворгүй орчин, чиг үүргийг шилжүүлснээс үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтын тогтвортой байдлыг алдагдуулах магадлалтай.</p>	<p style="text-align: center;"><b>Нийгэм-соёл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>Шууд бус нөлөөлөл</b></li> </ul> <p>Нягтлан бодох бүртгэлийн ажилтнууд санхүүгийн программаар үйл ажиллагаагаа явуулдгаас өөрийн хийж байгаа зүйлдээ тавих хяналт сул</p>
<p style="text-align: center;"><b>Эдийн засаг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>Шууд нөлөөлөл</b></li> </ul> <p>Эрх бүхий байгууллагаас хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны санхүүжилтийн эх</p>	<p style="text-align: center;"><b>Хүний нөөц</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>Шууд бус нөлөөлөл</b></li> </ul> <p>Тус улсад дотоод аудитын туршлагатай боловсон хүчин байхгүй, шинэ тутам боловч сургалт дутмаг, сургалт хийгдсэн</p>

үүсвэрийг шийдэхгүй байх, зарцуулах эрхийг олгохгүй байх	ч үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд үр нөлөө багатай
--	---

### **Хөгжлийн зорилго 1**

Удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, харилцаа хамтын ажиллагааны удирдлагыг сайжруулна.

### **Хөгжлийн зорилго 2**

Мэдлэгт суурилсан суралцагч байгууллагыг хөгжүүлж, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлнэ.

### **Хөгжлийн зорилго 3**

Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

### **Хөгжлийн зорилго 4**

Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангасан байна.

Боломж	Аюул занал
Байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явуулж байгаа эсэх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж дотоод хяналтын тогтолцооны суурь тавигдсан.	Удирдах ажилтан, нягтлан бодогч нарын болон ажилтнуудын санхүүгийн мэдлэг, чадвар, хууль эрх зүйн мэдлэгээс шууд хамааралтай. Аж ахуйн нэгж, байгууллагад дотоод хяналт төлөвшөөгүй. Иймээс аливаа эрсдэл гарах магадлалтай.
Бусад байгууллагатай ажлын уялдаа холбоо, гадаад харилцааг сайжруулах боломжтой.	Төсвийн санхүүжилтийн хэмжээ үйл ажиллагааны шаардлагыг хангадаггүй.

## ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД СТРАТЕГИУДЫН ЛОГИК ХОЛБОО

Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын санхүү, бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулан, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, санхүүгийн аливаа учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, харилцаа хамтын ажиллагааны үйлчилгээг

Менежментийг боловсронгуй болгоно.

Мэдлэгт суурилсан суралцагч байгууллагыг хөгжүүлж, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж,

Хүний нөөцийн удирдлагаар хангаж, боловсон хүчнийг хөгжүүлэн төлөвшүүлэх

Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

Хамт олны нийгмийн асуудлыг шийдвэрлэн.

## **СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УДИРДЛАГААС БАРИМТЛАХ БОДЛОГО**

Стратери төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, хяналт, үнэлгээ

Булган аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, харилцаа хамтын ажиллагааны удирдлагыг сайжруулах нь энэхүү стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх угтвар нөхцөл болох юм.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны стратеги төлөвлөгөөний улсын байцаагч, дотоод аудиторудыг бодлогын удирдлагаар хангаж, дунд хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн дунд болон богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөг нарийвчилан боловсруулж, хэрэгжүүлнэ. Эдгээр нь:

- Удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, харилцаа хамтын ажиллагааны удирдлагыг сайжруулах хөтөлбөр
- Мэдлэгт суурилсан суралцагч байгууллагыг хөгжүүлж, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлэх хөтөлбөр
- Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2019-2022 онуудад хэрэгжүүлэхийн тулд түүнтэй холбогдох хөгжлийн хөтөлбөр, төслүүдийг боловсруулах ажлыг шуурхай удирдлагаар хангаж, хэрэгжилтийг санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторуд хариуцан зохион байгуулна.

### **Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны хөгжлийн зорилго, стратегийг хэрэгжүүлэх бүтэц**

Стратери төлөвлөгөөнд тусгагдсан хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухай бүр хяналт- шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаварыг үнэлж дүгнэх ажлыг 4 үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

I-үе шат: Стратеги төлөвлөгөөний эхний үе шатны үнэлгээ хийх

Хугацаа: 2025 оны 12 сар

II-үе шат: Стратеги төлөвлөгөөний эцсийн шатны үнэлгээ хийх

Хугацаа: 2026 оны 12 сар

III-үе шат: Стратеги төлөвлөгөөний эцсийн шатны үнэлгээ хийх

Хугацаа: 2027 оны 12 сар

IV-үе шат: Стратеги төлөвлөгөөний эцсийн шатны үнэлгээ хийх

Хугацаа: 2028 оны 12 сар

Байгууллагын удирдлагын зүгээс стратеги төлөвлөгөө түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэлтэнд байнга хяналт тавина.

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан тодорхой зорилго, зорилтуудыг хангахад хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжүүлэх шаардлагатай.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад доор дурьдсан эрсдэл тохиолдолж болохыг анхаарах нь зүйтэй.

#### **1. Төр засгийн үйл ажиллагаанаас хамаарах эрсдэл**

1.1 Төрийн удирдлагын тогтворгүй байдал, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт

1.2 Эрх зүйн зохицуулалт хангалтгүй

#### **2. Нийгэм, эдийн засгийн орчноос хамаарах эрсдэл**

- 2.1 Эдийн засгийн бууралт, санхүү төсвийн хямралд орох  
 2.2 Байгууллага, аж ахуйн нэгжид дотоод хяналт төлөвшихгүй байх нь гарч болзошгүй эрсдэл буурахгүй байхад нөлөөлнө.

### 3. Байгууллагын дотоодод гарч болох эрсдэл

3.1 Удирдлагын зохистой харилцаа бүрдэхгүй байх, дунд анхан шатанд хариуцлага сулрах

3.2 Хамт олны хөдөлмөрийн үнэлэмж, урамшуулал, хариуцлага тооцох, систем оновчтой бусаас чанарын төлөө шударга өрсөлдөөн бий болохгүй байх, тогтвор суурьшил буурах, улмаар үйл ажиллагааны чанар үр нөлөө дээшлэхгүй байх

3.3 Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт, үнэлгээний бүтэц байгуулагдахгүй байх буюу байгуулагдсан ч сайн ажиллахгүйгээс төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, эрчимжүүлэх ажил хангалтгүй явагдах, үр өгөөж нь муудах зэрэг нөлөөллийг тооцох нь зүйтэй.

### САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2019	2020	2021	2022
1	Нэг.Удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр				
1.1	Байгууллагын өөрийн удирдлагыг бэхжүүлж, менежментийн чадамжийг дээшлүүлэх	+	+		
1.2	Байгууллагын соёл, дэг журмыг сахин биелүүлэх	+	+	+	+
1.3	Байгууллагын дотоод хяналтыг төлөвшүүлж, үр дүнг дээшлүүлэх	+	+	+	+
1.4	Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг харилцан уялдаатай, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд харилцагч, хамтран ажиллагч төрийн байгууллагуудын ажиллагаа, үр ашигтай түншлэлийг өргөжүүлж, тэдний идэвхи оролцоог бий болгох	+	+	+	+
2	Хоёр. Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр				
2.1	Ажилтнуудын сургалтын хэрэгцээг нарийвчлан тодорхойлж, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлэх	+	+	+	+
2.2	Хүний нөөцийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулан албан тушаалын тодорхойлолтод тусгах	+	+	+	+
2.3	Төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэв ахиулах, албан тушаалд дэвшүүлэх, бодлогын зөв, оновчтой, ил тод тогтолцоог бүрдүүлж, ажилтнуудын мэдлэг, ур чадварын эрүүл өрсөлдөөний зарчмыг баримтлах	+	+	+	+
3	Гурав. Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр				
3.1	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмолжуулах	+		+	
3.2	Ажилтнуудын нийгмийн гол асуудал болох орон сууцны нөхцөлийг сайжруулах		+	+	+
3.3	Хамт олны нийгмийн бусад нийтлэг асуудлыг шийдвэрлэх	+	+	+	+

4	Дөрөв. Санхүүгийн чиглэлээр				
4.1	Төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж өр авлагагүй ажиллах	+	+	+	+
4.2	Төсвийн гүйцэтгэл, мэдээ тайлан ил тод байх	+	+	+	+
4.3	Шилэн дансанд мэдээллийг тухай бүр байршуулах	+	+	+	+
4.4	Шил ажиллагааны тайланг улирал бүр гаргах	+	+	+	+

### Удирдлага, зохион байгуулалтын хөгжлийн хөтөлбөр

Хөтөлбөрийн зорилго:

Удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, харилцаа хамтын ажиллагааны удирдлагыг сайжруулна.

Хөтөлбөрийн дэвшүүлж буй зорилтууд:

1. Байгууллагын өөрийн удирдлагыг бэхжүүлж, менежментийн чадамжийг дээшлүүлэх
2. Байгууллагын соёл, дэг журмыг сахин биелүүлэх
3. Байгууллагын дотоод хяналтыг төлөвшүүлж, үр дүнг дээшлүүлэх
4. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг харилцан уялдаатай, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд харилцагч, хамтран ажиллагч төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үр ашигтай түншлэлийг өргөжүүлж, тэдний идэвхи оролцоог бий болгох

### ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйл ажиллагаа	Хийгдэх ажлууд ба хэрэгжүүлэх арга зам	Хариуцах нэгж, хамтран ажиллагч	Төсөв
Байгууллагын өөрийн удирдлагыг бэхжүүлж, менежментийн чадамжийг дээшлүүлэх	Байгууллагын менежментийг чадамжийн индексийг тодорхойлох,	Албаны дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч	
Байгууллагын соёл, дэг журмыг сахин биелүүлэх	Захирах, захирагдах ёсны зарчмыг баримтлах Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, ёс зүйтэй хяналтыг төлөвшүүлэн, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах Төрийн үйлчилгээг цаг алдалгүй, олон нийтэд чанартай, хүртээмжтэй соёлтой хүргэж, тэдний итгэл үнэмшлийг хүлээх	Байгууллагын удирдлага, улсын ахлах байцаагчид, улсын байцаагчид, ажилтнууд	



<p>Байгууллагын дотоод хяналтыг төлөвшүүлж, үр дүнг дээшлүүлэх</p>	<p>Байгууллагын дотоод хяналтын журмыг боловсронгуй болгож, төлөвлөгөөт хяналтыг тогтмолжуулж, үр дүнг хамт олны хурлаар хэлэлцүүлэх, тайлагнах</p> <p>Дотоод хяналтын бүртгэлийг нэгж бүрт хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх</p>	<p>Албаны дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч</p> <p>Дотоод хяналтын баг</p>	
<p>Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг харилцан уялдаатай, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд харилцагч, хамтран ажиллагч төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үр ашигтай түншлэлийг өргөжүүлж, тэдний идэвхи оролцоог бий болгох</p>	<p>Байгууллага, аж ахуй нэгжүүдийн дотоод хяналтыг төлөвшүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх</p> <p>Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын мэдээллийг олон нийтэд хүргэх, шаардлагатай тохиолдолд төрийн бусад байгууллагуудтай хамтарч ажиллах</p>	<p>Байгууллагын удирдлага</p> <p>Улсын ахлах байцаагч, Улсын байцаагчид, дотоод аудитор</p>	

**Хөтөлбөрийг хамрах цар, хүрээ:** Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны удирдлага, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор

**Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа:**

Үе шатууд	Үйл ажиллагаа	Цаг хугацаа	Тайлбар
Нэгдүгээр үе шат	Судалгаа шинжилгээ	2025.01.01 2025.12.31	Улсын байцаагч, дотоод аудитор
Хоёрдугаар үе шат	Удирдлагын бүтэц зохион байгуулалтын уялдаа холбоог сайжруулах	2025.12.31 2026.12.31	
Гуравдугаар үе шат	Өөрчлөлтийг хэвшүүлэх үе шат	2026.01.01 2027.12.29	

**Хөтөлбөрийн санхүүжилт:** Байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд .

**Хүрэх үр дүн:**

- Менежментийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.
- Багаар ажиллах чадвар дээшилнэ.
- Байгууллагын чадамжийн индексийг тодорхойлж хэвшинэ.

## Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр

### Хөгжлийн зорилго:

Мэдлэгт суурилсан суралцагч байгууллагыг хөгжүүлж, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлнэ.

### Хөтөлбөрийн дэвшүүлж буй зорилтууд:

1. Ажилтнуудын сургалтын хэрэгцээг нарийвчлан тодорхойлж, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн тасралтгүй үргэлжлэх сургалтын хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлэх
2. Хүний нөөцийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулан албан тушаалын тодорхойлолтод тусгах
3. Албан тушаалд дэвшүүлэх бодлогын зөв, оновчтой, ил тод тогтолцоог бүрдүүлж, ажилтнуудын мэдлэг, ур чадварын эрүүл өрсөлдөөний зарчмыг баримтлах

### ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйл ажиллагаа	Хийгдэх ажлууд ба хэрэгжүүлэх арга зам	Хариуцах нэгж, хамтран ажиллагч	Төсөв
<p>Ажилтнуудын сургалтын хэрэгцээг нарийвчлан тодорхойлж, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлэх</p>	<p>Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах тасралтгүй боловсролын сургалтуудад хамрагдах</p> <p>Дотоод аудитуудын үндсэн мэдлэг олгох сургалтанд хамрагдах</p> <p>Улсын салбарын мэргэшсэн дотоод аудиторын давтан сургалтанд аудиторуудыг бүрэн хамруулах</p> <p>Шинээр нэвтэрсэн тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа бүрэн ашиглах чадварыг дотооддоо сайжруулах</p>	<p>Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч</p> <p>Улсын байцаагчид</p> <p>Дотоод аудиторууд</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>
<p>Хүний нөөцийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулан албан тушаалын тодорхойлолтод тусгах</p>	<p>Ажлын ачааллын бодит байдлын талаар судалгаа хийх</p> <p>Ажлын байрны шинжилгээнд үндэслэн, ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэх</p>	<p>Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч</p>	

Төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэв ахиулах, албан тушаалд дэвшүүлэх бодлогын зөв, оновчтой, ил тод тогтолцоог бүрдүүлж, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх	Хөдөлмөрийн бүтээмжийг бодитой үнэлдэг тогтолцоог бий болгож, байгууллагын дотоод дүрэм, журамд тусгах	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч	
---	--	--	--

**Хөтөлбөрийн хамрах хүрээ:** Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны удирдлага, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, дотоод аудитор, ажилтнууд

**Хөтөлбөрийн үргэлжлэх цаг хугацаа**

Үе шатууд	Үйл ажиллагаа	Цаг хугацаа	Тайлбар
Нэгдүгээр үе шат	Судалгаа шинжилгээ	2025.01.01 2025.12.31	
Хоёрдугаар үе шат	Ажилтнуудыг холбогдох сургалтанд дэс дараатайгаар хамруулах	2025.12.31 2026.12.31	
Гуравдугаар үе шат	Ажилтнуудыг холбогдох сургалтанд дэс дараатайгаар хамруулах	2026.12.31 2027.12.31	
Дөрөвдүгээр үе шат	Ажилтнуудыг холбогдох сургалтанд дэс дараатайгаар хамруулах	2027.12.31 2028.12.31	

**Хөтөлбөрийн санхүүжилт:**

**Хүрэх үр дүн:**

- Хүний нөөцийн удирдлагыг бэхжүүлж хүний нөөцийг хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
- Байгууллагын дотоод уур амьсгал, соёлыг дээшлүүлж, өндөр бүтээмж бүхий боловсон хүчинтэй болно.
- Үйл ажиллагааны чанар сайжирч нэр хүнд дээшилнэ.

## Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөгжлийн хөтөлбөр

### Хөгжлийн зорилго

Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

### Хөгжлийн дэвшүүлж буй зорилтууд:

1. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмолжуулах
2. Ажилтнуудын нийгмийн гол асуудал болох орон сууцны нөхцөлийг сайжруулах, орон сууцтай болох талаар холбогдох газруудтай хамтран ажиллах
3. Хамт олны нийгмийн бусад нийтлэг асуудлыг шийдвэрлэх

### ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйл ажиллагаа	Хийгдэх ажлууд ба хэрэгжүүлэх арга зам	Хариуцах нэгж, хамтран ажиллагч	Төсөв
Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмолжуулах	Ажилтнуудыг эрүүл мэндийн бүрдмэл үзлэгт жил бүр төлөвлөгөөний дагуу хамруулах Ажилтнуудыг чийрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч	
Ажилтнуудын нийгмийн гол асуудал болох орон сууцны нөхцөлийг сайжруулах	Орон сууцны хэрэгцээний талаар бодитой судалгаа гаргах Хэрэгцээнд тулгуурлан төлөвлөгөө боловсруулах	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч	
Хамт олны нийгмийн бусад нийтлэг асуудлыг шийдвэрлэх	<b>Тусламж:</b> Орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь зориулан нэг удаагийн санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх Шинээр гэр бүл болоход нь санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх Хүүхэд төрүүлэх, хүүхэд үрчлэн авахад нь санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх <b>Тэтгэмж:</b> Хүнд өвчтэй гэр бүлийн гишүүд (эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд)-ээ ажлаасаа	Албаны дарга	

	<p>чөлөөлөгдөн асарвал тэтгэмж олгох</p> <p>Байгалийн гамшиг, гэнэтийн осолд орж, орон байр, эд хөрөнгөний ноцтой хохирол учирсан тохиодоллд тэтгэмж олгох</p> <p>Удаан хугацаагаар өвчилсөн тохиолдолд тэтгэмж олгох</p>		
--	---	--	--

**Хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилтот бүлгүүд:** Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны удирдлага, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, дотоод аудитор

**Хөтөлбөрийн үргэлжлэх цаг хугацаа**

Үе шатууд	Үйл ажиллагаа	Цаг хугацаа	Тайлбар
Нэгдүгээр үе шат	Судалгаа шинжилгээ	2025.01.01 2025.03.31	
Хоёрдугаар үе шат	Нийгмийн асуудлыг батлагдсан төсвийн хүрээнд тухай бүр шийдвэрлэх	2025.03.31 2025.12.23	
Гуравдугаар үе шат	Батлагдсан төсвийн хүрээнд болон аймгийн удирдлагуудад асуудал дэвшүүлж, шийдвэрлүүлэх	2026.01.01 2028.12.24	

**Хөтөлбөрийн санхүүжилт :** Батлагдсан төсвийн хүрээнд

**Хүрэх үр дүн**

- Хамт олны нийгмийн бусад нийтлэг асуудлууд шийдвэрлэгдэнэ.
- Хамт олны орон сууцны асуудал тодорхой хэмжээнд шийдвэрлэгдэнэ.